ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 01 сарын 31 өдөр Дугаар 36/А/1270470 Мандалговь

*Зөрчил арилгах тухай*

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Соёлын төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитаар нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас ажилчдад 1,000,000.00 /Нэг сая/ төгрөгийн хантааз хийлгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т *Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно/,*Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д */Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/* заасныг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/,* Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас батлагдсан нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, журам, зааврыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Соёлын

[1] Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

002024117

төвийн эрхлэгч  Ө.Эрдэнэчимэг, нягтлан бодогч Т.Энхбат нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР Л.УРАНБИЛЭГ

**БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

**ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ**

Байгууллагын нэр: **Эрдэнэдалай сумын Соёлын төв**
Тайлант хугацаа: **2023 он**

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын холбогдох хүний | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| **А** | **1** | **3** | **4** | **5** | **6** | **7** | **8** | **9** | **10** |
| 1 | Шилэн данс хөтлөлт | Санхүүжилтийн орлого, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг хугацаа хоцроож мэдээллэсэн зарим сард мэдээллийг байршуулаагүй. | - | Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-т /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх/ | Санал тайлбар байхгүй. Хүлээн зөвшөөрсөн. | Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах; | Зөвлөмж хүргүүлэх | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ө.Эрдэнэчимэг Т.Энхбат |
| 2 | Хөрөнгийн данстай холбоотой асуудал | Түүх соёл, музейн дурсгалт зүйлсийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, мэргэжлийн байгууллагаар үнэлгээ тогтоолгоогүй. | - | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | Санал тайлбар байхгүй. Хүлээн зөвшөөрсөн. | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ө.Эрдэнэчимэг Т.Энхбат |
| 3 | Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой | Байгууллагын дарга өөртөө тушаал гарган түлш халаалтын зардлаас түлшний хөнгөлөлт олгосон | 94,200.00 | Төлбөрийг барагдуулах төлбөрийн акт тогтоох | Санал тайлбар байхгүй. Хүлээн зөвшөөрсөн. 2024.05.25-ны өдрийн дотор барагдуулъя | Актын төлбөрийг Дундговь аймаг дахь төрийн аудитын газарт 2024.05.25-ны дотор барагдуулж, хэрэгжилтийг ирүүлэх | Төлбөрийг барагдуулах төлбөрийн акт тогтоох | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ө.Эрдэнэчимэг Т.Энхбат |
| 4 | Хөрөнгийн данстай холбоотой асуудал | Нормын хувцас, зөөлөн эдлэл зардлаас ажилчдад хантааз хийлгэсэн. | 1,000,000.00 | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | Санал тайлбар байхгүй. Хүлээн зөвшөөрсөн. | Хугацаатай албан шаардлага хүргүүлэх | | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ө.Эрдэнэчимэг Т.Энхбат |
| | | **дүн** | **1,094,200.00** | | | | | | |

БЭЛТГЭСЭН: АУДИТОР Л.УРАНБИЛЭГ 2024.01.30

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР Х.НАРАНЦАЦРАЛ

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

ЗӨВШӨӨРСӨН: ЭРХЛЭГЧ Ө.ЭРДЭНЭЧИМЭГ

ЗӨВШӨӨРСӨН: НЯГТЛАН БОДОГЧ Т.ЭНХБАТ

4819281864
9034749 СБТ101460

е